



**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,  
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, тус Зохицуулах зөвлөлийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотод орон сууцны ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх байгууллагуудын хариуцаж буй барилга байгууламж, үйлчилгээний хамрах хүрээг бүртгэх журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан, Зохицуулах зөвлөлийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/11 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Тусгай зөвшөөрлийн алба /Г.Нарантуяа/, Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба /Б.Доржбат/-нд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТСУУРЬ



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргын 2018 оны 07дугаар сарын 09 –ний өдрийн А/31 тоот тушаалын хавсралт

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГЫН ХАРИУЦАЖ БУЙ ОРОН СУУЦНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭГ БҮРТГЭХ ДОТООД ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Орон сууцны ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын хариуцаж буй барилга байгууламж, үйлчилгээний хамрах хүрээг Зөвлөлийн мэдээллийн санд бүртгэх, түүнийг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих, холбогдох бүртгэл, судалгааг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Орон сууцны барилга, байгууламж, үйлчилгээний хамрах хүрээг бүртгэх журам нь салбарын статистик мэдээ гаргах, тайлан боловсруулах, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын хариуцаж буй барилга байгууламж, орон сууц, үйлчилгээний хамрах хүрээний талаарх мэдээллийг үнэн зөв гаргахад чиглэгдэнэ.
- 1.3 Энэхүү журам нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад нийцсэн байна.

Хоёр. Орон сууцны барилга байгууламжийг бүртгэх

- 2.1 Орон сууцны барилга, байгууламжийн бүртгэлийг мэдээллийн санд бүртгэн, хяналт тавих ажлыг Тусгай зөвшөөрлийн алба хариуцна.
- 2.2 Барилга байгууламж, үйлчилгээний хамрах хүрээг бүртгүүлэх хүсэлтийг ажлын алба хүлээн авч, 14 хоногийн дотор хянаж, бүртгэнэ.
- 2.3 Бүрдүүлсэн бичиг баримт шаардлага хангасан бол Зохицуулах зөвлөлд хүсэлт ирсэн өдрөөр тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад бүртгэж, мэдээллийн санд оруулна.

Гурав. Бүрдүүлэх бичиг баримт

- 3.1. Барилга байгууламж, үйлчилгээний хамрах хүрээг мэдээллийн санд бүртгэхдээ дараах баримт бичгийг үндэслэнэ. Үүнд:
  - 3.1.1. Албан хүсэлт /шинээр бүртгүүлэх барилга байгууламжийн хаяг, айл өрх, аж ахуйн нэгжийн тоо тодорхой тусгагдсан байна/
  - 3.1.2. Барилгын захиалагч болон ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан барилга, байгууламж, орон сууцны ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах гэрээ, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж хүлээлцсэн акт / нотариатаар баталгаажуулна/;
  - 3.1.3. “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ болон “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-иас олгосон техникийн нөхцөл;

- 3.1.4. Барилга байгууламжийг ашиглалтанд хүлээж авсан комиссын акт, дүгнэлт;
- 3.2. Хэрэв бичиг баримтын бүрдэлт шаардлага хангаагүй бол энэ тухай албан бичгээр хариу өгнө.

Дөрөв. Тайлагнах

- 4.1. Тусгай зөвшөөрлийн алба нь барилга, байгууламжийн бүртгэлтэй холбоотой тайлан мэдээ, судалгааг улирал бүр нэгтгэн, Зохицуулах зөвлөлийн даргын зөвлөлийн хуралд танилцуулна.
- 4.2. Ажлын алба тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүртгэлийн тайланг жилийн эцсийн дүнгээр гарган, Зөвлөлийн нэгдсэн тайланд оруулна.

Тав. Бусад зүйл

- 5.1. Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, барилга байгууламжтай холбоотой өмчийн аливаа маргаантай асуудлыг энэхүү журмаар зохицуулахгүй.

—oOo—